

БАТЛАВ:

БООМТЫН СЭРГЭЛТИЙН ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДАРГА  
МОНГОЛ УЛСЫН САЙД  
Б.ТУЛГА

**ХИЛИЙН ГАШУУНСУХАЙТ БООМТЫН 2035 ОН ХҮРТЭЛХ ХӨГЖЛИЙН ЕРӨНХИЙ  
ТӨЛӨВЛӨГӨӨ, ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ  
БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР**

2024 оны 2 сарын 29-ний өдөр  
Улаанбаатар хот

Дугаар №

|    |                   |  |
|----|-------------------|--|
| 1. | Зорилго           | <p>Монгол Улсын урт хугацааны “Алсын Хараа 2050” хөгжлийн бодлоготой нийцүүлэн хилийн боомтын төлөвлөлт, бүтээн байгуулалтыг хөрш улсын хил залгаа боомтын бодлого төлөвлөлттэй уялдуулах, хуучин хийгдсэн төлөвлөлт, зураг төслийг Боомтын шинэ сэргэлтийн бодлоготой уялдуулж, нийгэм эдийн засаг, гадаад дотоод нөхцөл байдал, шинэ тутам бий болж буй худалдаа эдийн засгийн нөөц боломжуудыг судлан үзсэний үндсэн дээр шинэчлэн сайжруулах чухал шаардлагатай байна. Улмаар боомтын удирдлага, үйл ажиллагаа, хяналтыг илүү үр дүнтэй зохион байгуулж дотоодын болон гадаадын нэмүү өртөг, нийлүүлэлтийн сүлжээнд нийгэм, эдийн засгийн өндөр өгөөжтэйгөөр нэгтгэх замаар боомтыг шинэ түвшинд хөгжүүлэх, экспорт импортыг зохистойгоор нэмэгдүүлэх, олон улсын түвшний транзит тээврийн зангилаа цэг болон хуурай боомтыг бий болгон хөгжүүлэх, байгаль орчинд ээлтэй “ногоон боомт”-ыг төлөвлөж иргэдийн эрүүл аюулгүй, тав тухтай амьдарч, ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлэх.</p> |
| 2. | Эрх зүйн үндэслэл | <p><b>1. Хууль тогтоомж</b></p> <ul style="list-style-type: none"><li>- Монгол Улсын Үндсэн хууль;</li><li>- Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль;</li><li>- Орон нутгийн эрх зүйн байдлын тухай хууль;</li><li>- Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль;</li><li>- Хот байгуулалтын тухай хууль;</li><li>- Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль;</li><li>- Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хууль;</li><li>- Газрын тухай хууль;</li><li>- Монгол Улсын хилийн тухай хууль</li><li>- Бусад холбогдох хууль.</li></ul>  |

|    |  |   |
|----|--|---|
|    |  | <p><b>2. Тогтоол шийдвэр, бодлогын баримт бичиг</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Монгол Улсын Их хурлын 2020 оны 52 дугаар тогтоол, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг;</li> <li>- Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоол, “Шинэ Сэргэлтийн бодлого” Монгол Улсын дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг;</li> <li>- Монгол Улсын Их хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсыг 2021-2025 онд хэрэгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 2.4.3, 2.4.9 дэх заалт;</li> <li>- Монгол Улсын Их хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2020- 2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.7, 2.5.11 дэх заалт;</li> <li>- Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”;</li> <li>- Монгол Улсын Их Хурлын 2011 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал”;</li> </ul>  |
| 3. | Байршил, эдийн засаг, нийгмийн хөгжлийн байдал | <p>Хилийн Гашуунсухайт авто замын боомт нь 1992 оны 07 дугаар сарын 21-ны өдөр байгуулагдсан. Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт байрладаг. БНХАУ-ын ӨМӨЗО-ны Урдын дунд хошууны Баяннуур аймгийн Урдын дунд хошуунд байрладаг Ганцмод боомттой хиллэдэг. Энэхүү боомт нь Монгол Хятадын хилийн 703 дугаар тэмдгийн орчимд байна. Улаанбаатар хотоос 800 км, Өмнөговь аймгийн төвөөс 342 км, Ханбогд сумаас 130 км зайд байршдаг.</p> <p>Монгол, Хятадын хилийн боомт тэдгээрийн дэглэмийн тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу хоёр талын зэрэглэлтэй, байнгын горимтой боомт юм.</p> <p>Одоогийн байдлаар тус боомтод 22000 гаруй иргэн ажиллаж амьдран, 370 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж, 39 гаалийн хяналтын талбайгаар хоногт 1200 - 1500 автомашинаар жилд ойролцоогоор 35 сая тн нүүрс, зэсийн баяжмалын экспорт хийгдэж байна.</p> <p>Төмөр зам, авто зам, зарим бүтээн байгуулалтын талаар:</p> <p>УИХ-ын 2018 оны 06 дугаар сарын 29-ны өдрийн “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого батлах</p> |

|    |  |   |
|----|--|---|
|    |  | <p>тухай” УИХ-ын 2010 оны 32 дугаар тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 71 дүгээр тогтоолын 3.2.4.2-т Тавантолгой-Гашуунсухайт 267 км, “Алсын хараа-2050” хөгжлийн бодлогын тэргүүлэх ач холбогдол бүхий төмөр замын чиглэл болгон барихаар тус тус тусгасан. ЗГ-ын 2018 оны 242-р тогтоолоор Тавантолгой-Гашуунсухайт, чиглэлийн төмөр замын төслийг хэрэгжүүлэх “Тавантолгой төмөр зам” ХХК-г байгуулахаар шийдвэрлэсэн. Уг төмөр зам ашиглалтанд орсноор жилд 30-50 сая тонн ачаа тээвэрлэх боломжтой.</p> <p>Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 250 км хүнд даацын хатуу хучилттай авто замын төсөл (2020-2030 он). “Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 250 км хүнд даацын хатуу хучилттай авто замын төсөл” “Зураг төсөл боловсруулах – барих – ашиглах – шилжүүлэх” (DBOT) төрлийн концессын гэрээг 2019 оны 03 дугаар сарын 29-ны өдөр байгуулсан. Одоогийн байдлаар Тавантолгой – Гашуунсухайт чиглэлийн 239 км хүнд даацын хатуу хучилттай 2 эгнээ бүхий авто замтай.</p> <p>Гашуунсухайт боомтод хийгдэж буй бүтээн байгуулалтууд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Ачаа тээврийн болон Зорчигч тээврийн 29 барилга, байгууламжийн ажил , иж бүрэн инженерийн шугам сүлжээний ажил 68.86%-ийн гүйцэтгэлтэй явж байна.</li> <li>- Хайрхан багт байршилтай албан хаагчдын 5 блок орон сууцны хотхон - 14.44%-ийн гүйцэтгэлтэй явж байна.</li> <li>- Авто зам - 2,5 км, Боомтын доторх зам талбай – 11.9 га, Ногоон байгууламж - 76680 м2, 1976 мод бут хийгдэх зураг төслийн дагуу бүтээн байгуулалтын ажил хийгдэж байна.</li> </ul> |
| 4. | Хамрах хүрээ, газар нутгийн хэмжээ, хүн ам | Төлөвлөлт хийх газрын хил хязгаарыг Монгол Улсын Боомтын Сэргэлтийн Үндэсний хорооны хурлаар тогтооно.  |
| 5. | Боловсруулах ажлын үе шат                  | <ul style="list-style-type: none"> <li>- Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулахдаа дараах үе шатны дарааллаар хийнэ.</li> </ul> <p><b>I үе шат боловсруулах</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах;</li> <li>- Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах;</li> <li>- Хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах;</li> </ul> <p><b>II үе шат хэлэлцүүлэх, санал, зөвлөмж авах</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болон хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг захиалагч талтай</li> </ul>   |

|    |                  |  |
|----|------------------|--|
|    |                  | <p>зөвшилцөж, санал авах</p> <ul style="list-style-type: none"> <li>- Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төслийг аж ахуйн нэгж, бизнесийн байгууллагууд дунд хэлэлцүүлэх, санал авах, зөвшөөрөлцөх;</li> <li>- Мэргэжлийн ашиглагч байгууллагуудаас санал авч зөвшилцөх;</li> <li>- Мэргэжлийн байгууллага, эрдэмтэн, судлаачдын дунд хэлэлцүүлэг хийж санал, зөвлөмж авах;</li> </ul> <p><b>III үе шат батлуулах</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Зураг төсөл /ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, инженер геологийн судалгаа, өндөржилт/-д улсын экспертизийн нэгдсэн дүгнэлт гаргуулах;</li> <li>- Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний холбогдох хууль тогтоомжийн дагуу мэргэжлийн байгууллагуудаар батлуулах;</li> <li>- Монгол Улсын Засгийн газар, Боомтын Сэргэлтийн Үндэсний хорооны хурлаар батлуулах</li> </ul>  |
| 6. | Ашиглах материал | <p><b>Монгол Улсын хуулиуд:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль</li> <li>- Байгаль орчныг хамгаалах тухай хууль;</li> <li>- Усны тухай хууль;</li> <li>- Эрчим хүчний тухай хууль;</li> <li>- Газрын тухай хууль;</li> <li>- Хот байгуулалтын тухай хууль;</li> <li>- Барилгын тухай хууль;</li> <li>- Монгол улсын хилийн тухай хууль;</li> <li>- Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хууль;</li> <li>- Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль;</li> <li>- Гаалийн тухай хууль;</li> <li>- Геодез зураг зүйн тухай хууль;</li> <li>- Орон сууцны тухай хууль;</li> <li>- Бусад Монгол Улсын хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомж;</li> </ul> <p><b>Бодлогын баримт, бичиг, төсөл, хөтөлбөрүүд:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц;</li> <li>- “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг;</li> <li>- Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоол, “Шинэ Сэргэлтийн бодлого” Монгол Улсын дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг;</li> <li>- “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”;</li> <li>- “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, Улсын Их Хурлын 2020 оны 8 дугаар сарын</li> </ul> |

28-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаан;

- “Монгол Улсын усны нөөцийн нэгдсэн менежментийн арга хэмжээний төлөвлөгөө” Засгийн газрын 2013 оны 389 дүгээр тогтоолоор батлагдсан;
- Салбаруудын хэмжээнд хэрэгжиж буй дотоодын болон олон улсын төсөл, хөтөлбөрүүд;
- Тухайн бүс нутаг болон аймагт хэрэгжиж буй бусад төсөл, хөтөлбөрүүд;
- Монгол, Хятадын хилийн боомт, тэдгээрийн дэглэмийн тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр
- “Төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого” Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 333 дугаар тогтоолоор батлагдсан;
- Хөрш орны хил залгаа боомтын Хөгжлийн ерөнхий төлөвлөлттэй холбоотой баримт бичгүүд;
- Бүс нутаг, хөрш орны дунд болон урт хугацааны бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүд;
- Бусад холбогдох баримт бичгүүд.

**Норм норматив, стандарт:**

- Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм (БНБД 30-01-04);
- Хот, суурины хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах аргачилсан заавар (УББ 11-202-00);
- Хот, суурины дэвсгэр газарт хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ өгөх аргачилсан заавар (УББ 30-201-09);
- Барилга байгууламжийн инженер-экологийн судалгаа (БД 11-102-07);
- Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах, зөвшөөрөлцөх, экспертиз хийх дүрэм; (ЗТБХБ-ын сайдын 2011 оны 226 дугаар тушаал)
- Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх дүрэм;
- “Хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төслийг олон нийтээр хэлэлцүүлэх журам” /ЗТБХБ-ын сайдын 183 дугаар тушаал/;
- MNS 3237:1989 Ерөнхий төлөвлөгөө. Зам тээврийн таних тэмдэг, дүрслэл;
- MNS 5873:2008 Барилгын зураг. Ерөнхий төлөвлөгөөний ажлын зургийн таних тэмдэглэгээ;
- MNS 130 11091: 2007 Барилгын зураг. Ландшафтын зураг боловсруулах;
- MNS 6055: 2009, Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар
- MNS 6056:2009, Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зам

|   |                 |   |
|---|-----------------|---|
|   |                 | <p>-MNS 5682-2006, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн орон зайн төлөвлөлт” барилгын дүрэм,<br/> - “Авто зогсоол” БНБД 21-05-10<br/> - Бусад холбогдох норматив баримт бичиг, стандартууд;</p>   |
| 7 | Ажлын иж бүрдэл | <p><b>БИЧИГЛЭЛИЙН БАРИМТ БИЧИГ</b></p> <p>1. <b><u>Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн төлөвлөгөө</u></b></p> <p>1.1. Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний тайлбар бичиг;<br/> 1.2. Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний тайлбар бичиг;<br/> 1.2. Инженер-геологийн судалгааны тайлан;<br/> 1.3. Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ;<br/> 1.4. Хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ;<br/> 1.5. Судалгааны материал.</p> <p>2. <b><u>Хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө</u></b></p> <p>2.1. Хэрэгжүүлэх арга хэмжээний тайлбар бичиг;<br/> 2.2. Хэрэгжүүлэх арга хэмжээний техник эдийн засгийн үзүүлэлт;<br/> 2.3. Хөрөнгө оруулалтын тооцоо, эх үүсвэр;<br/> 2.4. Төсөл хөтөлбөрийн жагсаалт, онцгой ач холбогдол бүхий төслүүдийн урьдчилсан ТЭЗҮ /Монгол, Хятад хэлээр/.</p> <p>3. <b><u>Товч танилцуулга</u></b></p> <p>Хэвлэлийн эх бэлтгэл, цаасны формат /сонголтоор/<br/> 3.1. Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хураангуй /Монгол, Хятад хэлээр;<br/> 3.2. Хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хураангуй /Монгол, Хятад хэлээр/;<br/> 3.3. Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний онцлог давуу талыг тусгасан хурлын тараах материал;<br/> 3.4. Олон нийтэд зориулсан тараах материал /брошюр/.</p> <p><b>ЗУРАГЛАЛЫН БАРИМТ БИЧИГ</b></p> <p>1. <b><u>Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө</u></b></p> <p>1.1 Хот орчмын бүсийн хөгжлийн тойм, нутаг дэвсгэрийн байршлын схем М1:25000<br/> 1.2 Одоогийн байдал, орчны тойм М1:10000<br/> 1.3 Хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ М1:10000<br/> 1.4 Ерөнхий төлөвлөгөөний үндсэн зураг М1:10000<br/> 1.5 Газар нутгийн үүргийн зориулалт, бүсчлэлийн төрөл М1:10000<br/> 1.6 Дэвсгэр нутаг, эдэлбэр газрын хуваарилалт М1:10000<br/> 1.7 Гудамж, зам, тээврийн сүлжээ М1:10000</p> |

- 1.8 Инженерийн шугам сүлжээний нэгдсэн зураг M1:10000
- 1.9 Дулаан хангамж MТ.10000
- 1.10 Ус хангамж, ариутгах татуурга M1:10000
- 1.11 Цахилгаан хангамж M1:10000
- 1.12 Холбоожуулалт M1:10000
- 1.13 Инженерийн бэлтгэл арга хэмжээ, өндөржилт, улаан шугам M1:10000
- 1.14 Цэцэрлэгжилт, ногоон байгууламж M1:10000
- 1.15 Байгаль орчин, аялал жуулчлалын хөгжлийн төлөвлөлт M1:10000
- 1.16 Гаалийн хяналт, тээвэр зохион байгуулалтын төлөвлөлт M1:10000
- 1.17 Түүх, соёлын дурсгалт барилга, цогцолборын зэрэглэл байршил M1:10000
- 1.18 Макет M1:5000 байхаас гадна 3D хэмжээст график болон хөдөлгөөнт зураглал, мөн файлаар /видео анимейшн/
- 1.19 Гамшгийн менежмент.

## **2. Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө**

- 2.1 Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний үндсэн зураг M1:5000
- 2.2 Дэвсгэр нутаг, эдэлбэр газрын хуваарилалт M1:5000
- 2.3 Гудамж, зам, тээврийн сүлжээ M1:5000
- 2.4 Инженерийн шугам сүлжээний нэгдсэн зураг M1:5000
- 2.5 Дулаан хангамж M1:5000
- 2.6 Ус хангамж, ариутгах татуурга M1:5000
- 2.7 Цахилгаан хангамж M1:5000
- 2.8 Холбоожуулалт M1:5000
- 2.9 Инженерийн бэлтгэл арга хэмжээ, өндөржилт, улаан шугам M1:5000
- 2.10 Цэцэрлэгжилт, ногоон байгууламж M1:5000
- 2.11 Гудамж зам дагуух хөндлөн огтлол
- 2.12 Эхний ээлжийн барилгажилт M1:5000
- 2.13 Макет M1:1000, 3Э хэмжээст график болон хөдөлгөөнт зураглал, файлаар /видео анимейшн/.

## **3. Хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө M1:10000**

- 3.1 Хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хүрээнд хэрэгжих томоохон төсөл, арга хэмжээний байршлын бүдүүвч зураг;

|    |  |   |
|----|--|---|
|    |  | <p>3.2 Төлөвлөлтийн үе шатны зураглал;</p> <p>3.3 Төлөвлөлтийн эхний ээлжинд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний байршлын бүдүүвч зураг 2024-2029 он;</p> <p>3.4 Төлөвлөлтийн дунд хугацаанд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний байршлын бүдүүвч зураг 2029-2035 он;</p> <p>3.5 Замын сүлжээний үе шатны зураглал;</p> <p>3.6 Инженерийн дэд бүтцийн үе шатны зураглал;</p> <p>3.7 Дахин төлөвлөлтийн үе шатны зураглал;</p> <p>3.8 Газар зохион байгуулалтын үе шатны зураглал;</p> <p>3.9 Гамшгийн менежмент үе шатны зураглал.</p> <p><b>БАРИМТ БИЧГИЙН ШААРДЛАГА:</b></p> <p><b>1. Бичиглэлийн баримт бичиг</b></p> <p>1.1. Ажлын файл /*.doc, *.pdf, *.xlsx/</p> <p>1.2. Батлагдсан баримт бичиг скайнер /*.pdf, *.jpd/</p> <p><b>2. Зураглалын баримт бичиг</b></p> <p>2.1. Ажлын файл /*.dwg, *.shp, *.lumion, *.max, *.cdr/</p> <p>2.2. Батлагдсан баримт бичиг скайнер /*.jpg, *.pdf/</p> <p><b>3. Товч танилцуулга</b></p> <p>3.1. Олон нийтийн хэлэлцүүлэг, хурлын танилцуулга /*.ppt/</p> <p>3.2. Хурлын тараах материал /*.doc, *.pdf/</p> <p>3.3. Олон нийтэд тараах материал /*.jpg, *.pdf/</p> <p>3.4. Төлөвлөлтийн онцлогийг харуулсан товч танилцуулга анимэйшн 5 минутаас багагүй /*.mp4, 1080HD/</p> <p>Батлагдсан ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн төлөвлөгөө, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг (зураг, бичиглэл)-ийг хэвлэмэл болон файл байдлаар 6 хувь бэлтгэж захиалагчид эх хувь 1, хуулбар 1 хувийг, барилгын хөгжлийн төвийн архивт 1 хувийг, аймаг, сумын ЗДТГ-т тус бүр 1 хувийг хүлээлгэж өгнө.</p> |
| 8. | Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний зорилтуудын хүрээнд шийдвэрлэх үндсэн асуудлууд | <p><b>Төлөвлөлтийн хугацаа: 2024-2035 он</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Улс, бүс, аймаг, сумын нийгэм, эдийн засгийн хөгжлийн чиг хандлага, бүлэг суурингийн тогтолцоотой уялдуулан, орон нутгийн хөгжлийн онцлог, нөөц боломжид тулгуурлан хилийн боомтод тавигдах шаардлагад нийцүүлэн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах;</li> <li>- Боомтын шинж чанар, хөгжлийн чиглэлийг тодорхойлох</li> <li>- БНХАУ-ын хил залгаа боомтын төлөвлөлттэй уялдуулах</li> <li>- Ачаатай болон ачаагүй тээврийн хэрэгслийн зогсоол, чингэлэг хадгалах талбайг төлөвлөх</li> <li>- Биржээр арилжаалсан нүүрсний экспортын тээвэр хийхэд зориулсан тусгай гарц, зогсоолын талбайг</li> </ul>  |



|  |  |  |
|--|--|--|
|  |  | <p>төлөвлөх</p> <ul style="list-style-type: none"> <li>- Өмнө хийгдсэн инженер-геодизийн судалгаа болон ерөнхий төлөвлөлтөд анализ дүгнэлт хийж, шинэчлэн сайжруулах</li> <li>- Боомтын төлөвлөлтийн газрын хэмжээг тодорхойлж, боомтын үйл ажиллагааны төрөл болон зориулалтаар бүсчилж, худалдаа үйлчилгээ, аялал жуулчлал, тээвэр логистик, үйлдвэрлэл, ногоон байгууламж зэрэг төрлүүдэд ангилах</li> <li>- Боомтын тээвэр зохион байгуулалтын зураглалыг тодорхойлох, авто замын уулзвар, үндсэн болон туслах авто замуудыг зураглах</li> <li>- Усан хангамж, ус зайлуулах суваг, үерийн хамгаалалт, цахилгаан, харилцаа холбоо зэрэг бүх төрлийн шугам хоолойг төлөвлөж, тохижилтын төлөвлөгөө гаргах</li> <li>- Хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөлтөд дотоодын болон гадаадын нөөц боломж, эрэлт хэрэгцээн, нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж бизнес, аж үйлдвэрийн төслүүдийг нарийвчлан тусгах, тэдгээрийн хөрөнгө оруулалтын хэлбэр, боломжуудын талаар санал дэвшүүлэх</li> <li>- Сэргээгдэх эрчим хүчний нөөцийг ашиглах төслийг төлөвлөлтөд тусгах</li> <li>- Өмнөговь аймгийн хөдөө аж ахуйн салбарыг боомтын хөгжилтэй уялдуулж, нэмүү өртөг шингээсэн, олон улсын стандартыг хангасан үйлдвэрлэлийн төслийг тусгах</li> <li>- Аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх боломжийн талаар төлөвлөлтөд тусгах</li> <li>- БНХАУ-ын далайн боомтуудтай холбогдох дэд бүтэц, логистикийн судалгааг хийх</li> <li>- Экологи - хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ өгсний үндсэн дээр тухайн нутаг дэвсгэрт ажиллаж амьдарч байгаа хүн амын нийгмийн эрэлт хэрэгцээнд нийцсэн архитектур, барилгажилт, тохижилт бүхий орон зайн зохистой бүтэц, эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлэх;</li> <li>- “Хот байгуулалтын тухай” хуулийн 13 дугаар зүйлд заасан үндсэн бүсчлэлийг хот байгуулалтын норм ба дүрэм, журмын дагуу төлөвлөх, тусгай зориулалтын бүсэд хамаарах хил, гааль, төмөр зам, хорио цээрийн бүсүүд, усны эрүүл ахуйн, эрчим хүчний хамгаалалтын зурвас газрыг тогтоох;</li> <li>- Хилийн боомтын нэгж хугацаанд дамжин өнгөрөх хүчин чадлыг тодорхойлж, үүнтэй уялдуулан барилга байгууламжийн хүчин чадлыг нарийвчлан тогтоох;</li> <li>- Хилийн хяналтын байгууллага /хил хамгаалах, гааль,</li> </ul> |
|--|--|--|

|     |   |   |
|-----|---|---|
|     |   | <p>мэргэжлийн хяналт, гадаадын иргэн харьяат/-уудын хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай барилга байгууламж, тоног төхөөрөмжийг хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тусгаж өгөх.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Инженер-геологийн нөхцлөөс хамааруулан иженерийн бэлтгэл арга хэмжээ болон байгалийн аюултай үзэгдэл, гамшигаас урьдчилан сэргийлэх, элсний нүүдэл, цөлжилтөөс хамгаалах зэрэг арга хэмжээг төлөвлөх буюу эрсдэл өндөртэй газарт цэцэрлэгт хүрээлэн, биеийн тамирын талбай зэрэг барилгажилт багатай бүс төлөвлөх;</li> <li>- Олон нийт, соёл, үйлчилгээний төв нь барилгажилтын хувьд харилцан уялдаа сайтай, орон зайн харьцаа, архитектур төлөвлөлтийн хувьд цогцолбор байх чиглэлийг баримтлах;</li> <li>- Норм, дүрмийн дагуу ногоон байгууламж, цэцэрлэгт хүрээлэн, спорт, амралтын талбай, авто машины зогсоол зэргийг төлөвлөх;</li> <li>- Төлөвлөлтийн шийдлийг үе шатаар хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлж, хөрөнгө оруулалтын тооцоог гаргаж, хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх талаар санал боловсруулах;</li> <li>- Ашиглах үүрэг зориулалт тодорхой бус талбайг нөөц талбайн бүсэд тооцож төлөвлөнө.</li> </ul> |
| 9.  | Инженерийн байгууламж, шугам сүлжээний эх үүсвэр, хангамж | <p>Инженерийн хангамжийг техникийн оновчтой шийдлийн дагуу эдийн засгийн хувьд үр ашигтай, орчин үеийн дэвшилтэт, байгаль орчинд ээлтэй технологитой байхаар төлөвлөх</p> <p><i>Цахилгаан хангамж:</i>- Төвлөрсөн хангамжтай (сэргээгдэх эрчим хүчтэй уялдуулах)</p> <p><i>Дулаан хангамж:</i> - Төвлөрсөн хангамжтай</p> <p><i>Усан хангамж:</i> - Төвлөрсөн хангамжтай</p> <p><i>Ариутгах татуурга:</i>- Төвлөрсөн хангамжтай</p> <p><i>Холбоожуулалт:</i> - Төвлөрсөн хангамжтай</p> <p>Боомтын зам, тээврийн сүлжээг бүс нутаг, орон нутгийн суурь дэд бүтэцтэй уялдуулан төлөвлөх</p> <p>Эхний ээлжинд өнөөгийн нөхцөлд боомтын үйл ажиллагааг хэвийн явуулахад зайлшгүй шаардлагатай инженерийн хангамжийн асуудлыг шийдвэрлэх.</p>   |
| 10. | Орон сууцны хангамж                                       | <p>Боомтод ажиллах хил хяналтын байгууллагууд болон ААН-ийн ажиллагсадын орон сууцны хангамжийн тодорхой хувийг Хилийн боомт, Өмнөговь аймгийн Ханбогд сумын төлөвлөлттэй уялдуулан төлөвлөх, ингэхдээ түр хугацааны ажиллагсад болон зочдыг байрлуулах түрээсийн орон сууцыг тооцож төлөвлөх;</p>  |

|     |               |  |
|-----|---------------|--|
|     |               | Цэцэрлэг, сургууль, эмнэлэг, соёл, ахуйн үйлчилгээний төв, спорт цогцолбор зэрэг барилга байгууламжийн хүчин чадлыг нарийвчлан тогтоосны үндсэн дээр төлөвлөх;   |
| 11. | Онцгой нөхцөл | <ul style="list-style-type: none"> <li>- Засгийн газрын 2010 оны 4-р сарын 28-ны өдрийн 102 дугаар тогтоолоор батлагдсан “Хилийн боомтын үлгэрчилсэн ерөнхий төлөвлөгөө”-ний зарчмыг баримтлан төлөвлөлтөд тусгах;</li> <li>- Хилийн боомтын аюулгүй байдлыг хангахад шаардлагатай тоног төхөөрөмж иж бүрэн төлөвлөх</li> <li>- Боомтын зам, тээврийн сүлжээг төлөвлөхдөө улсын хилээр нэвтэрч буй зорчигч, тээврийн хэрэгслийн замыг тус тусдаа байж огтлолцохгүй байхаар төлөвлөх;</li> <li>- Одоо үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг доголдуулахгүй нөхцөлийг хангаж төлөвлөх</li> <li>- Гаалийн хяналтын бүс нь гаалийн хяналтын технологи ажиллагаанд нийцсэн, тухайлбал улсын хилээр орж байгаа болон гарч байгаа зорчигч, тээврийн хэрэгсэл тусгаарлагдсан байх;</li> <li>- Зорчигч болон экспорт, импортын бараа, тээврийн хэрэгслийн хяналт шалгалтыг тусад нь хийхээр төлөвлөх;</li> <li>- Хими, физик, биологийн бохирдолтой болон хорио цээртэй зүйлээр халдварласан бараа, бүтээгдэхүүнийг устгах нөхцлийг бүрдүүлсэн устгалын бүс байгуулах;</li> <li>- Ундны болон ахуйн хэрэгцээний усны асуудлыг онцгой судлан шийдлийг гаргах;</li> <li>- Хилийн боомтын суурьшлын бүсийг хил хамгаалах байгууллагын тогтоосон хэсэгт төлөвлөх;</li> <li>- Боомтын хүчин чадлыг тодорхойлж, шалган нэвтрүүлэх цогцолборыг төлөвлөх, холбогдох байгууллагуудын саналыг тусгаж төлөвлөх;</li> <li>- Хилийн боомтын газрын зураглал, инженер- геологийн судалгаа, ерөнхий төлөвлөгөөг тусгай зөвшөөрлийн эрхтэй байгууллагаар иж бүрэн хийлгэх;</li> <li>- Тухайн орон нутгийн байгаль, цаг уур, газар зүйн нөхцөл, нийгэм, эдийн засгийн онцлогийг тусгасан барилгажилт, тохижилт бүхий орон зайн төлөвлөлт, архитектурын онцгой шийдлийг гаргах</li> <li>- Урьд хийгдсэн хөрсний болон усны хайгуулын судалгаануудыг судлах;</li> <li>- Хот байгуулалтын иж бүрэн үнэлгээнд үндэслэн хилийн боомт орчмын төлөвлөлтийг тодорхойлох;</li> <li>- Төвийн хэсгийн барилгажилт, тохижилт, орон зайн архитектурын шийдлийг тусгайлан авч тусгах;</li> <li>- -Засгийн газраас төмөр зам, авто замын талаар баримталж буй бодлоготой уялдуулан төлөвлөх;</li> </ul> |

|     |  |   |
|-----|--|---|
|     |  | <ul style="list-style-type: none"> <li>- Нүүрс тээврийн жолооч, хилээр зорчиж буй иргэдэд үйлчлэх үйлчилгээний төв, авто зогсоол, зочид буудал төлөвлөх,</li> <li>- Эрдэс баялаг түүхий эд, бараа бүтээгдэхүүнд шинжилгээ хийх лаборатори төлөвлөх,</li> <li>- Эрдэс баялаг түүхий эдээс дээж авах, шинжлэх зам талбайг төлөвлөх,</li> <li>- Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнд шинжилгээ хийх лаборатори төлөвлөх</li> <li>- Амьд мал тусгаарлах, халдваргүйжүүлэх, тээвэрлэх зам талбай, орон зайг төлөвлөх</li> <li>- Тэсэрч дэлбэрэх, аюултай ачааны агуулах, тээвэр логистийн бүтцийг төлөвлөх</li> <li>- Сэргээгдэх эрчим хүчний нөөцөөр цахилгаан хангах төлөвлөлтийг хийх</li> </ul>  |
| 12. | Боловсруулах хугацаа                   | Захиалагч гүйцэтгэгч талуудын хооронд байгуулсан гэрээгээр зохицуулна.  |
| 13. | Шаардагдах хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр | <ol style="list-style-type: none"> <li>1. Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах;</li> <li>2. Хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах<br/><br/>(Улсын төсвийн хөрөнгө оруулалт, гадаадын буцалтгүй тусламж)</li> </ol>   |
| 14. | Захиалагч байгууллага                  | <ol style="list-style-type: none"> <li>1. Боомтын Сэргэлтийн Үндэсний хороо</li> <li>2. Хилийн боомтын захиргаа</li> </ol>  |
| 15. | Гүйцэтгэгч байгууллага                 | <ol style="list-style-type: none"> <li>1. Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах байгууллага нь “хот байгуулалтын тухай” хуулийн 11.2-т заасны дагуу зураг төслийн тусгай зөвшөөрөлтэй, сонгон шалгаруулалтаар шалгарсан аж ахуйн нэгж байгууллага гүйцэтгэнэ. Хэрэв сонгон шалгарсан аж ахуйн нэгж нь гадаадын хуулийн этгээд бол тухайн улсдаа болон олон улсад ижил төстэй ажил гүйцэтгэж байсан, тусгай зөвшөөрлийн дагуу 5-с доошгүй жил үйл ажиллагаа явуулсан байгууллага байна.</li> <li>2. Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний “Хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө” боловсруулах байгууллага нь менежментийн зөвлөх үйлчилгээний мэргэжлийн байгууллага, эсвэл аж ахуй нэгж байна. Хэрэв сонгон шалгарсан аж ахуйн нэгж нь гадаадын хуулийн этгээд бол тухайн улсдаа болон олон улсад ижил төстэй ажил гүйцэтгэж байсан, тусгай зөвшөөрлийн дагуу 5-с</li> </ol> |

|     |                          |  |
|-----|--------------------------|--|
|     |                          | доошгүй жил үйл ажиллагаа явуулсан байгууллага байна.  |
| 16. | Зөвшөөрөлцөх байгууллага | <ul style="list-style-type: none"> <li>- Төлөвлөлтийн үндсэн шийдлийг эскизийн шатанд БХБЯ, ГЗБГЗЗГ, “Барилгын хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын дэргэдэх Хот байгуулалт, зураг төсөл, төлөвлөлтийн институт, аймаг, сумын захиргаа, Аймгийн Ерөнхий архитектор, ГХБХБГ, Хилийн боомтын үндэсний зөвлөл, Хилийн хяналтын байгууллагууд, Хилийн боомтын захиргаа болон бусад холбогдох байгууллагуудтай харилцан тохиролцож, зөвшөөрөлцөх;</li> <li>- Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг Барилга хот байгуулалтын яамны “Архитекторын болон хот төлөвлөлтийн орон тооны бус мэргэжлийн зөвлөл”-ийн хурлаар хэлэлцүүлэн эскизний шатанд зөвшилцөх;</li> <li>- Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төсөлд Хот байгуулалтын тухай хуулийн 7.1.5-д заасны дагуу хот байгуулалтын баримт бичигт улсын экспертизийн дүгнэлт гаргуулах;</li> <li>- Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төслийг Боомтын сэргэлтийн үндэсний хорооны хурлаар хэлэлцүүлэх;</li> <li>- Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг Хот байгуулалтын тухай хуулийн 6.1.6-д заасны дагуу хот байгуулалтын баримт бичгийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулах.</li> </ul> |